

# Мод үржүүлгийн газрын төлөвлөлт ба мод сөөгний тарьц суулгацыг бэлтгэх

МОД ҮРЖҮҮЛГИЙН ИНЖЕНЕР Г.БАТЦЭЦЭГ

2022 ОН

# АГУУЛГА

- ❖ МОД ҮРЖҮҮЛГИЙН ГАЗАР ГЭЖ ЮУ ВЭ?
- ❖ МОД ҮРЖҮҮЛГИЙН ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ
- ❖ МОД ҮРЖҮҮЛГИЙН ГАЗРЫН ХӨРС БОЛОВСРУУЛАЛТ
- ❖ МОД ҮРЖҮҮЛГИЙН ГАЗАРТ ТАРИЛТ ХИЙХ.

# Мод үржүүлгийн газрыг байнгын болон түр гэж хоёр ангилдаг

## ❖ БАЙНГЫН МОД ҮРЖҮҮЛГИЙН ГАЗАР

- Тусгай зураг төслөөр, тогтмол ажиллахаар байгуулагддаг.
- Талбайгаар нь жижиг, дунд, том гэж ангилдаг

## ❖ ТҮР ЗУУРЫН МОД ҮРЖҮҮЛГИЙН ГАЗАР

- Ойжуулалт хийх бүс нутгийг түшиглэн ойн цоорхой, ойгүй талбайг ашиглан 5 хүртэлх жилийн хугацаатайгаар байгуулдаг.

## Талбай сонгох (MNS 6138:2010)



- Мод үржүүлгийн газар байгуулах талбайг сонгохдоо хөрс, усан хангамж, уур амьсгал зэрэг байгаль орчин болон эдийн засгийн нөхцлийг харгалзан үзнэ.
- Мод үржүүлгийн газрын талбайг хэмжээнээс нь хамааруулан 0,5-1га, 3-4 га-гаар хэсэгчлэн, голдуу тэгш өнцөгт талбайд хуваарилан зохион байгуулна.
- Газрын гадарга тэгш байх ба 2-3 градусаас дээшгүй налуутай байна. Уулын дэвсэг хажуу газар бол 12 градус хүртэл налуутай байж болно.

- **Ойн бүсэд:** Сул чандруужсан элсэнцэр, хөнгөн шавранцар, бараан, хар шороон, хар хүрэн
- **Ойт хээрт:** Чандруужсан, хөнгөн шавранцар ба элсэнцэр бараан саарал, хар шороон, хар хүрэн
- **Хээрт:** Хөнгөн ширхэгийн бүрэлдэхүүнтэй хар хүрэн, хүрэн
- **Цөлөрхөг хээрт:** Элсэнцэр, цайвар хүрэн, говийн бор хөрстэй газар байх нь тохиромжтой.

**MNS 6263 : 2011**

- ▶ Мод ургах хамгийн чухал хүчин зүйл болох хөрс, усны РН буюу хүчил шүлтийн хэмжээ. Хөрсний шинж чанар, үржил шимт байдал зэргийг сайтар судалж, үүнийхээ үндсэн дээр тухайн орчин, нөхцөлийг нь бүрдүүлсэн **мод үржүүлгийн газар** байгуулдаг.
- ▶ Мод үржүүлгийн газар байгуулах талбайн хөрс шим тэжээлийн элементээр баялаг, үржил шимтэй үеийн зузаан 25-аас 40 см-ээс багагүй.
- ▶ Хөрсний РН 4,5-7,0 байна. Сонгон авч байгаа үржүүлгийн талбайд хөрсний зүсэлт авч, үндсэн давхаргуудын физик агрохимийн шинж чанарыг тодорхойлох, услах усны химийн найрлагын шинжилгээ хийх ба хөнөөлт шавж, элдэв өвчний халдвар байгаа эсэхийг судалсан байх ёстой.
- ▶ Усны давсны хэмжээ (0,1-0,5) %-иас ихгүй байна.

ХӨРСНИЙ  
ДАВХАРГА


ХӨРСНИЙ  
ДАВХАРГА

ХӨРСНИЙ  
ДАВХАРГА

ХӨРСНИЙ  
ДАВХАРГА

ХӨРСНИЙ  
ДАВХАРГА

ХӨРСНИЙ  
ДАВХАРГА



# Анхаарах нь

- **Хөрс:** Шавран, хужирлаг, намагжсан, чулуурхаг, үндэслэг ишт хог ургамал ихтэй хөрстэй газрыг сонгож болохгүй.
- **Ус:** Илүүдэл ус тогтохоор нам дор газар, хөрсний усны түвшин ойр газрыг сонгон авч болохгүй.
- **Газрын байрлал:** Эргэн тойрондоо хаалттай хонхор газар байж болохгүй. Цас, мөс, борооны усны үерт автагдахааргүй газар сонгоно.






# МОД ҮРЖҮҮЛГИЙН ГАЗРЫН ТӨЛӨВЛӨЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:

- Мод үржүүлгийн талбайг зөв зохион байгуулах нь талбайг бүрэн гүйцэт, тодорхой дэс дараатай удаан хугацаагаар ашиглахын үндэс нь болж өгдөг.

- ❖ Хашаа
- ❖ Хамгаалалтын зурвас
- ❖ Худаг /ёмкост/
- ❖ Зам талбай
- ❖ Хүлэмж
- ❖ Бойжуулах хэсэг
- ❖ Зоорь
- ❖ Эх ургамлын талбай
- ❖ Жимс жимсгэний талбай
- ❖ Агуулах
- ❖ Ажилчдын байр
- ❖ Үртэс бууц хар шороо буулгах хэсэг



## **Мод үржүүлгийн газрын талбайг зохион байгуулах**

- Мод үржүүлгийн газар нь зорилго, үйлчлэх хугацаа, үйлдвэрийн чадамж зэргээсээ хамаарч үрийн хэсэг, бойжуулах хэсэг, эх ургамлын хэсэг, дендрарийн хэсэгтэй байж болно.
- Талбайн зохион байгуулалтыг тарих модны төрөл, зүйл, гаргах үр, суулгац материалыг харгалзан тодорхой дараалалтай, бүрэн гүйцэд тасралтгүй ашиглахаар хийсэн байна.
- Зам, суваг, шуудуу, хамгаалалтын ойн зурвас, аж ахуйн барилга байгууламж зэргийг нарийн төлөвлөж, зохион байгуулсан байна.



# Хамгаалалтын хашаа



Хашаа:

- Мал
- Мэрэгч амьтад
- Бусад



# Хамгаалалтын зурвас


Ач холбогдол:

- Байгалийн хүчтэй салхи, хүйтрэлт, хуурайшилт зэрэг, цаг уурын сөрөг нөлөөллийг эрс бууруулж, жимс жимсгэний ургамлын цэцэглэлт, тоос хүртэлт, жимслэлт, өсөлт, хөгжилт, ургацын хэмжээ, чанарыг сайжруулах таатай бичил орчин бүрдүүлэхэд оршино.



- Цаг уурын нөхцөл, газрын өндөр намаас шалтгаалан 3-4 эгнээ шилмүүст, навчит мод, сөөг байна.
- Талбайн доторх хэсгүүдийн дундуур мод, сөөгөөр 1-2 эгнээ зурвас байгуулна.
- Зурвасны эгнээн дэх модны хооронд 2-3 м, сөөгний хооронд 0,3-0,5 м, эгнээний хооронд 2 м зайтай байна.

### An Example of the Effects of a Windbreak on Wind Speed.







## Усалгаа, худаг, цөөрөм

- Мод үржүүлгийн газрын талбайг услаж болох байнга ундаргатай, тасарч ширгэдэггүй гол, горхи, цэнгэг нуур, цөөрмийн усыг ашиглахаар түшиглэн байгуулна.
- Усны эх үүсвэрийн хол ойр, бороо орох давтамж, улирлын чанараас хамааран усыг шууд талбай руу эсвэл цистерн болон далан руу татан хуримтлуулж хэрэглэдэг. Үүнээс гадна борооны усыг хуримтлуулж усжуулалтын хэрэгцээнд мөн ашиглаж болдог.
- Усгүй нөхцөлд өрмийн гүн худаг ашиглана.

- Усны нөөцийг хэрхэн хэрэглэх, хэрхэн талбайг  
услах зэргээс хамааран өөр өөр төрлийн  
усжуулалтыг ашигладаг. Ерөнхийдөө усжуулалтын  
зорилго нь талбайг нэгэн жигд усаар хангаж  
ингэснээр тариалж буй ургамал нь хэрэгцээт усан  
хангамжаа авах явдал юм.

-Бороожуулагч

усалгаа

-Манажуулагч

усалгаа

-Дуслын усалгаа...,

гэх

мэт.



# Зам талбай

- Мод үржүүлгийн газрын талбайн бүх замууд хоорондоо холбогдсон, үйлчилгээний машин, трактор чөлөөтэй эргэх, зөрөх боломжтой байна.



# МОД СӨӨГНИЙ ТАРЬЦ СУУЛГАЦЫГ БЭЛТГЭХ



## Мод сөөгний үр түүх

1. Ургаа модноос
2. Унасан модноос
3. Усны мандалаас
4. Газраас

## ҮР ТАРИЛТАНД БЭЛТГЭХ

- Мод, сөөгний үрийг тарилтанд бэлтгэхэд **MNS 5994:2009** стандартын шаардлагыг хангасан байх шаардлагатай.
- Тарилтанд бэлтгэж байгаа мод, сөөгний үрийн цэвэршилт, амьдрах чадвар, чийг, соёололт, 1000 үрийн жин зэргийг стандартаар нь лабораторид шинжлүүлсэн байна.
- **Үрийн тайван байдал:** Үр боловсорсны дараа тодорхой хугацаанд тайван байдалд орох
- **Үр ариутгах:** Химийн төрөл бүрийн бодис ашиглан үрээ ариутгах явц
- **Үр эртжүүлэх:** /стратификаци/ Үрийг тайван байдлаас нь гаргахын тулд зориудаар тарилтанд бэлтгэх арга
- **Үр чийглэх:** Үрийг хөөтөл нь чийглэх
- **Үр цаслах:** Савласан үрээ уутанд жигд тараан цасан дор хийх
- **Үр элслэх:** Мод, сөөгний үрийг элстэй үелүүлэн хийж, температурын тодорхой нөхцөлд тогтоосон хугацаанд байлгахыг хэлнэ.

**MNS 6253-1 : 2011**

<b>№</b>	<b>Ургамлын нэр</b>	<b>Усанд дэвтээх хугацаа</b>	<b>Цаслах, элслэх хугацаа /хоног/</b>	<b>Үрийг тарилтанд бэлтгэх арга</b>
1	Шинэс, Нарс	2 хоног	30	Цаслах
2	Гүйлс, Бүйлс	2 хоног	45	Цаслах, элслэх
3	Долоогоно	60% чийгтэй болтол дэвтээнэ	240	Цаслах, элслэх
4	Шар хуайс	1 хоног	30	Цаслах, элслэх



- Үр тарих хэмжээг үрийн чанар, соёололт, ургах эрчим, цэвэршилт, мянган үрийн жин, мод үржүүлгийн газрын байгаль газар зүйн нөхцөл, ургуулах агротехникийн аргаас хамааран харилцан адилгүй байдаг.



- Мод, сөөгний үрийг тарихын өмнө хөрсийг **MNS 6263 : 2011** стандартын дагуу боловсруулан, талбайг тэгшлэн хөрсийг сайжруулсан байна.



- Модожсон мөчир, ногоон мөчрөөр тарих





## Бойжуулах талбай:

Үр болон мөчрөөр үржүүлсэн тарьцыг бойжуулах зориулалтын талбай.

- Бойжуулах талбайд шилжүүлэн суулгах шилмүүст, навчит мод болон сөөгний тарьц нь стандарт шаардлага хангасан байна. **MNS 6254 : 2011**
- Бойжуулах талбайн хөрсийг эртний ба хар уриншаар боловсруулна.
- Бойжуулах талбайд шилжүүлэн суулгах тарьцыг намар навч унасны дараа буюу хавар навч, шилмүүс задрахаас өмнө суулгана
- Бойжуулсан талбайд ургуулсан суулгацыг хот, суурин газрыг цэцэрлэгжүүлэх, тариалангийн талбайд зурвас байгуулах, хөрсийг элэгдлээс хамгаалах, гуу жалга, эрэг ганга, элсийг бэхлэх зэрэг ойжуулалтын ажилд хэрэглэнэ.



# **АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА**



**БИДНИЙ ТАРИХ ТЭРБУМ МОД  
ТАНЫ ТАРИХ НЭГ МОДНООС ЭХЭЛНЭ**